



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,  
Утас/Факс: (976) 7032 3253,  
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2020. 07. 28 № 286  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.3, 37.5 дахь хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох тус сумын Ардчилсан намаас ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн 2020 оны ээлжит сонгуульд оролцох сумын Ардчилсан нам нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой нийцүүлэн сонгуулийн мөрийн хөтөлбөрөө боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгийн хамт аймаг дахь Төрийн аудитын байгуулагад ирүүлж, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль 37 дугаар зүйлийн 37.5-д заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Аймаг дахь Төрийн аудитын газар нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох сумын Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ “Төрийн аудит MNS 6817-1:2020” Тулгуур зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020” Нийцлийн аудитын зарчим, “Төрийн аудит MNS 6817-8:2020”, Өвөрхангай аймгийн нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, “Өвөрхангай аймгийн эдийн засгийг 2014-2024 онд хөгжүүлэх бодлогын баримт бичиг”, Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

015030549

D:\Auditiiin gazar\baiguullagiin dotood barimt\A4


## Дүгнэлт

Сумын Ардчилсан намын “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгууль”-д оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын заалт, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сумын Ардчилсан намын мөрийн хөтөлбөр / ... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сумын сонгуулийн хороонд

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Л.ЛАМААЧИН



# ШИНЭ БАРУУНБАЯН-УЛААН

хөгжлийн  
бодлого **2020**



ХҮН БҮРД ОРЛОГО  
ӨРХ БҮРД ӨСӨЛТ✓

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАРУУНБАЯН-УЛААН СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН  
АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД  
ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2020

ШИНЭ БАРУУНБАЯН-УЛААН, ШИНЭ ХӨГЖИЛ  
СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИТХ-ЫН СОНГУУЛИЙН 2020 ОНЫ  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАРУУНБАЯН-УЛААН СУМЫН  
АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Монгол Улсын тусгаар тогтнол, Үндэсний эрх ашиг, Үндсэн хуульт Ардчиллаа хамгаалан бэхжүүлж, хувь хүний эрх, эрх чөлөө, шударга ёс хуулийн засаглал, чөлөөт зах зээл, иргэний нийгмийн зарчимд суурилсан тогтвортой хөгжлийн төлөөх баруун төвийн намын хувьд Монгол хүн бүр хүсэл мөрөөдөлтэй, өрх бүр аз жаргалтай амьдрах хөгжлийн боломжийг дэмжсэн, иргэд нь эрх чөлөөтэй, эрх тэгш, хариуцлагатай, Ардчилсан Монгол Улсаа хөгжүүлэхийг ЭРХЭМ ЗОРИЛГО болгож,

- Монгол хүний эрх, эрх чөлөө, бие даасан байдлыг хангах
- Хувийн өмч, өрсөлдөөнт зах зээл, төрийн хязгаарлагдмал оролцоо, хуулийн засаглал
- Үндэсний өв уламжлал, түүх соёлоо дээдлэн үнэт зүйлээ болгон тунхагласан

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАРУУНБАЯН-УЛААН СУМЫН АРДЧИЛСАН НАМ 2020-2024 оны аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцох “ШИНЭ БАРУУНБАЯН-УЛААН, ШИНЭ ХӨГЖИЛ” мөрийн хөтөлбөрөө Та бүхэндээ толилуулж байна.

УРИА: ХҮН БҮРД ОРЛОГО – ӨРХ БҮРД ӨСӨЛТ

НЭР: ШИНЭ БАРУУНБАЯН-УЛААН, ШИНЭ ХӨГЖИЛ



## **ГАРЧИГ**

**НЭГ. ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨ**

- 1.1. ӨРСӨЛДӨХ ЧАДВАРТАЙ БОЛОВСРОЛ
- 1.2. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ
- 1.3. ХҮН АМЫН ХӨГЖИЛ ХҮН АМЫН ХӨГЖИЛ, ӨРХ ГЭР БҮЛ
- 1.4. АЖЛЫН БАЙР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ
- 1.5. НИЙГМИЙН ХАМГААЛАЛ
- 1.6. СОЁЛ, УРЛАГ, СПОРТ

**ХОЁР. ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ**

- 2.1 .ӨСӨЛТИЙН БОДЛОГО ЖИЖИГ ДУНД БИЗНЕС, БИЗНЕСИЙН ДАРХЛАА
- 2.2. ДЭД БҮТЭЦ
- 2.3. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ
- 2.4. ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

**ГУРАВ. ЭЗЭН МОНГОЛ**

- 3.1. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ, “ШИНЭ ХӨДӨӨ” ХӨТӨЛБӨР
- 3.2. “ЧИНЭЭЛЭГ МАЛЧИН” ХӨТӨЛБӨР
- 3.3. ШИНЭ ХӨДӨӨ ХӨТӨЛБӨР
- 3.4. БЭЛЧЭЭР АШИГЛАЛТ
- 3.5. МАЛ АЖ АХҮЙ
- 3.6. ГАЗАР ТАРИАЛАН

**ДӨРӨВ. ХУУЛЬТАЙ МОНГОЛ**

- 4.1. ИРГЭНДЭЭ ҮЙЛЧИЛДЭГ ЗАСАГЛАЛ

**ТАВ. АЮУЛГҮЙ, АМГАЛАН МОНГОЛ**

- 5.1. ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ ЭКОСИСТЕМИЙН ТЭНЦВЭРТЭЙ БАЙДАЛ



## НЭГ. ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨ

### 1.1. ӨРСӨЛДӨХ ЧАДВАРТАЙ БОЛОВСРОЛ

- Хүүхэд бүрийг хөгжүүлж, бүтээлч сэтгэлгээтэй, өөртөө итгэлтэй, эх нутгийнхаа байгаль, түүх, үндэсний хэл соёл, уламжлалаар бахархдаг хүмүүжил олгох “Зөв Монгол хүүхэд” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- Хүүхэд гэр бүл, цэцэрлэг, сургуулийн орчинд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, орчны эрүүл мэндийг сайжруулах бодлогыг нийгмийн эрүүл мэндийн үндсэн чиглэл болгоно.
- Хүүхдэд ээлтэй, эрүүл аюулгүй тоглоомын төв байгуулах.
- Архинд донтолтын эсрэг архи согтууруулах ундаа хэрэглэдэггүй, эрүүл идэвхитэй амьдралын клуб байгуулахыг дэмжинэ.
- Малчин өрхийн 6-8 настай хүүхдийг гэрээр сургах гэрийн сургалтын тогтолцоог хэрэгжүүлнэ.
- Амжилттай хэрэгжиж буй “Мянган инженер” хөтөлбөрт орон нутгийн залуучуудыг хамруулна.
- Соёлын төвийн үйлчилгээг сайжруулж хөдөөгийн багт бүрт урлаг соёлын үйлчилгээг хүргэх нөхцөл боломжоор хангаж, техник хэрэгсэлийг шинэчлэн, орчин үеийн техник хэрэгсэлээр бүрэн хангана.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг соёлын үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах, тэдний авьяас, хөдөлмөр бүтээлийг дэмжиж ажиллана.
- Багш нарын мэдлэг, ур чадварыг тухай бүрд нь дээшлүүлж, давтан сургахад орон нутгаас дэмжлэг үзүүлэх ажлыг эхлүүлнэ.
- Сургууль, цэцэрлэгийн удирдлагыг мэргэшсэн, тогтвортой, улс төрөөс хараат бус байх нөхцөлийг бүрдүүлж, удирдах албан тушаалтныг чөлөөлөх, томилох асуудалд сумын иргэдийн төлөөллөөс бүрдсэн “Боловсролын зөвлөл”-ийн саналыг харгалздаг болгоно.
- Хүн ам, албан хаагч, ажилчдын цахим боловсролыг дээшлүүлж, бүх нийтийн цахим боловсролыг (Digital Literacy) дээшлүүлнэ.
- Орон нутгийн боловсон хүчний чадварыг сайжруулах, хүн амын шилжилт хөдөлгөөнийг бууруулах зорилгоор боловсон хүчнийг бодлогоор бэлтгэж шаардлагатай санхүүжилтийг орон нутгийн төсвийн санхүүжилтээс дэмжих ажлыг эхлүүлнэ.

### 1.2. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

- Иргэдийн халдварт болон халдварт бус өвчлөл, эх болон нярайн эндэгдлийг бууруулж, урьдчлан сэргийлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.
- Сумын эрүүл мэндийн төвийн стандартыг ханггуулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.
- Хавдрын эрт илрүүлэг, хавдрын өвчлөлийг бууруулах зорилгоор шаардлагатай оношуур, төхөөрөмжөөр хангах. Энэ чиглэлээр эмч нарыг сургалтанд хамруулах.



- Хүнийг өвдөхөөс нь өмнө урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоог өрх гэрийн түвшинд тогтмол хийдэг эрүүл мэндийн үйлчилгээний шинэ хэлбэрийг бий болгож, гэрийн эмчийн шинэ тогтолцоонд шилжүүлнэ
- Иргэн бүрийг насны бүлэгт нь тохирсон урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулна.
- Бага насны хүүхдийн амны хөндийн эрүүл ахуй, шүдний урьдчилан сэргийлэх үзлэг, эмчилгээг тогтмол хийж, сумын эрүүл мэндийн төвд шаардлагатай орон тоог бий болгох, боловсон хучнийг бэлтгэх ажлыг эхлүүлнэ.
- Багийн эмч нарын мэргэжил, боловсролыг тасралтгүй дээшлүүлэхэд орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлнэ.
- Тэтгэвэр тогтоолгосон ахмад эмч нарыг эрүүл мэндийн төвд зөвлөхөөр ажиллуулахыг бодлогоор дэмжинэ.
- Сумын эрүүл мэндийн төвийг түргэн тусламжийн машинаар хангана.
- Түргэн тусламжийн үйлчилгээг цаг алдалгүй иргэдэд үзүүлэхэд тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг хангах зорилгоор баг тус бүрт тээврийн хэрэгслийн парк шинэчлэлт хийнэ.
- Иргэн бүрийн эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулна.

### 1.3. ХҮН АМЫН ХӨГЖИЛ, ӨРХ ГЭР БҮЛ

- Хүүхэд, залуучуудын хөгжлийн төв байгуулна.
- Хүүхдийн хүмүүжил, төлөвшлийн асуудалд онцгой анхаарч, цэцэрлэгийн өмнөх насны хүүхдийг хүмүүжүүлэх олон талт ажлыг зохион байгуулна.
- Гэр бүлийн гишүүн бүрд гэр бүлийн боловсрол олгох, ажил хөдөлмөр эрхлэх, санхүү, бизнесээ хөгжүүлэх, амьдрах орчноо хамтдаа сайжруулах, мэдлэг ур чадварын сургалт, зөвлөмжөөр хангагдах боломжийг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.
- Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэж, дарамт, мөлжлөгийн бүх хэлбэрээс хамгаалах хуулийн хэрэгжилтийг сайжруулна.
- Ээжүүд, эмэгтэйчүүдэд зориулсан төрөл бүрийн чадваржуулах сургалтыг Насан туршийн боловсролын нэгжийг түшиглэн зохион байгуулна.

### 1.4. АЖЛЫН БАЙР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийг сайжруулахад чиглэсэн бодлого хэрэгжүүлнэ.
- Хөдөлмөрийн зах зээл дээр эрэлтийн судалгааны чанарыг сайжруулж, хэрэгцээтэй байгаа ажил, мэргэжлийг эдийн засгийн салбар, ажил мэргэжлээр нарийвчлан гаргаж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын элсэлттэй нягт уялдуулна.
- Гарааны бизнес буюу “Старт-ап”-ыг хөгжүүлэхийг бодлогоор дэмжинэ.
- ЖДУ болон Малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингэсэн байхаар хөтөлбөр боловсруулан ажиллана.

### 1.5. НИЙГМИЙН ХАМГААЛАЛ



*[Handwritten signature]*

1. Ахмадын өргөөг бүрэн тохижуулж, байнгын үйл ажиллагаатай болгож тогтвортжуулна.
2. Төрөөс малчидруу чиглэсэн нийгмийн даатгалын бодлогыг оновчтойгоор хэрэгжүүлж тэдний нийгмийн баталгааг хангана.
3. Эх хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусlamж, үйлчилгээний чанарыг хүн бүрт хүргэнэ. .

## 1.6. СОЁЛ, УРЛАГ, СПОРТ

1. Монгол хүнийг төлөвшүүлэхэд нөлөөлөх уламжлалт өв соёлыг бодлогоор дэмжиж ажиллана. .
2. Соёлын биет ба биет бус өвийг хадгалан хамгаалах, сэргээн засварлах, түүнийг хамгаалан цуглуулагч, тээн уламжлагч нарыг сурталчлан дэмжиж, үндэсний агуулгатай дэлхийн сонирхлыг татахуйц үнэ цэнтэй өвийг хөгжүүлнэ.
3. Түүх соёлын дурсгалт газрын хамгаалалтыг сайжруулж, соёлын өвийг хамгаалагч, харгалзагч нарын урамшууллыг нэмэгдүүлнэ.
4. Спортын улс, бүсийн хэмжээний уралдаан, тэмцээнийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ, улс бүс, олон улсын тэмцээнд оролцох баг тамирчдын зардалд орон нутгийн зүгээс дэмжлэг үзүүлдэг тогтолцоог бий болгоно.
5. Орон нутгийн онцлог спорт болох “Шатрын өргөө” байгуулж, бодлогоор дэмжин ажиллана.
6. Багийн спортын хөгжилд онцгой анхаарч, залгамж чанарыг хадгалан хөгжүүлэх зорилгоор байнгын бэлтгэлтэй байх нөхцлийг бүрдүүлнэ.
7. Үндэсний өв соёлыг хадгалсан сур, шагайн спортын хөгжилд онцгой анхаарч ажиллана.
8. Уламжлалт өв соёл уртын дуу, морин хуурыг өвлүүлэн үлдээхэд онцгой анхаарч мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэнэ.
9. Орчин үеийн чанар стандартад нийцсэн урлаг спортын цогцолбор төв барина.

## ХОЁР. ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ

### 2.1. ӨСӨЛТИЙН БОДЛОГО ЖИЖИГ ДУНД БИЗНЕС, БИЗНЕСИЙН ДАРХЛАА

1. Сум хөгжүүлэх сангийн зээлийг иргэдэд тэгш хүртээмжтэй, ялгаварлалгүйгээр хариуцлагатай олгоно.
2. Сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг жил бүр тогтвортойгоор нэмэгдүүлэх бодлогыг барьж нутгийн Брэнд бүтээгдэхүүн бий болгоход СХС-ын бодлогоор дэмжинэ.
3. Ажиллах хүчийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах, ажлын байр олноор бий болгохыг нэн тэргүүний зорилт гэж үзэн шинэ ажлын байрыг бий болгох бүтээн байгуулалт, бизнесийн төслүүдийг бүх талаар дэмжиж хөгжүүлнэ.
4. Төрийн албанаас бизнесийн салбарт шилжсэн баялаг бүтээгч иргэдийнхээ бизнес эрхлэлтийн, хөрөнгө оруулалтын анхны санхүүжилтийг бодлогоор дэмжинэ.
5. Төрийн албанаас эрт тэтгэвртээ гарч жижиг дунд, бичил бизнесийн салбарт шилжин баялаг бүтээх иргэдээ эдийн засгийн бодлогоор дэмжинэ.



6. Эрдэс баялгийн, малын гаралтай түүхий эдийг боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүнд, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэн ажлын байрыг бий болгохыг дэмжинэ.
7. Төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаанд орон нутгийн аж ахуйн нэгж болон хувийн хэвшлийг давуу эрхтэй оролцуулахыг дэмжиж ажиллана.
8. Орон нутгийн аж ахуй нэгж, компаниудын чадавх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх төслүүдийг дэмжинэ. Мал аж ахуй, газар тариалан, гахай, тахиа, зөгийн аж ахуйд суурилсан орон нутгийн онцлог шинэ брэнд бүтээгдэхүүний бизнес загвар хөгжүүлэхийг дэмжинэ.
9. Иргэд, орон нутаг, олон нийтийн оролцоо, олон улсын байгууллагуудтай хамтран ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлж, байгаль орчныг нөхөн сэргээнэ.

## 2.2. ДЭД БҮТЭЦ

1. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу шинэ суурьшлын төлөвлөлтөнд эрчим хүч, цэвэр бохирын инженерийн шугам сүлжээг бий болгох ажлыг эхлүүлнэ.
2. Үүрэн телефоны бүх сүлжээний өргөтгөл, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
3. Стандартад нийцсэн камерын системийн чанарыг сайжруулна..
4. Гэр хорооллын гудамжийг цэгцэлж, жишиг гудамжууд бий болгоно.
5. А зэрэглэлийн бүсэд дахин төлөвлөлтийг хийж, орчин үеийн загвар төлөвлөлт бүхий үйлчилгээний төв бий болгоно.

## 2.3. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

1. Орон нутгийн онцлогт нийцсэн “Хүрэн хадны рашаан” “Элсний сувилал”-ыг аялал жуулчлалын нэгдсэн маршрутанд хамруулж хөтөлбөр боловсруулан таниулан сурталчиллах ажлыг эрчимжүүлнэ.
2. “Хүрэн хадны рашаан” “Элсний сувилал”-ыг өндөр хүчдэлд холбоно.
3. Уламжлалт Тэмээний баярын арга хэмжээг өргөжүүлж, Гадаадын жуулчдын өртөөчилсэн тэмээн аялалыг сумын иргэдэд хүртээмжтэй байдлаар өргөжүүлэн зохион байгуулна.

## 2.4. ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

1. Хүн амын гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний дотоод хэрэгцээг чанартай хүнсээр хүртээмжтэй хангаж, дотоод зах зээл дэх хүнсний нийлүүлэлтийн сүлжээнд аюулгүй байдлын тогтолцоог нэвтрүүлнэ.
2. Жимс, жимсгэний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хэрэгцээг дотооддоо хангахад чиглэгдсэн хувийн хэвшлийн санаачилгыг дэмжин нутгийн брэнд бүтээгдэхүүн бий болгоход бүх талаар дэмжинэ.
3. Орон нутгийн иргэдийн хүнсний хэрэгцээгээ өөрөө хангах, хүлэмжийн аж ахуй эрхлэх санаачилгыг бүх талаар дэмжинэ.



- Дөрвөн улирлын хүлэмжийн төсөл хөтөлбөрийг хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлнэ.
- Төмс, хүнсний ногооны төрөлжсөн зоорь барих ажлыг дэмжинэ.
- Орон нутгийн онцлогийг харуулсан ингэний сүү, сүүн бүтээгдэхүүнийг боловсруулах ЖДҮ-ийг дэмжин нутгийн брэнд бий болгоход анхаарч ажиллана.
- “Богдын Арын ямааны ааруул” нутгийн брэнд бий болгоно.

## ГУРАВ. ЭЗЭН МОНГОЛ

### 3.1. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ, ШИНЭ ХӨДӨӨ” ХӨТӨЛБӨР

- Бэлчээрийн доройтлыг бууруулах зорилгоор бэлчээрийн менежментийг сайжруулна.
- Бэлчээрийн болон хүн амын усан хангамжийг сайжруулж худаг ус цэгийг нэмэгдүүлнэ.
- Хог хаягдлын менежментийг сайжруулна.
- “Шинэ баг”-төсөл хэрэгжүүлнэ.

### 3.2. “ЧИНЭЭЛЭГ МАЛЧИН” ХӨТӨЛБӨР

- Мал аж ахуйн салбарыг эдийн засгийн үр ашигтай, орчин үеийн шинэ технологи, инновацад суурилж, хөгжүүлэн мэдлэг бүхий малчин бизнесмен болгох замаар тогтвортой орлого бүхий хүчтэй дундаж давхаргыг тэлэх бодлого хэрэгжүүлнэ.
- Иргэдийн санаачилгад суурилсан “Чинээлэг малчин” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

### 3.3. ШИНЭ ХӨДӨӨ ХӨТӨЛБӨР

- Max, сүү цагаан идээ, малын гаралтай түүхий эдийг завсрын дамжлагагүйгээр худалдан борлуулах төв байгуулна
- Малчдын нөхөрлөл хоршоо байгуулах, ажлыг бодлогоор дэмжин, малчин өрхийн орлогыг нэмэгдүүлнэ

### 3.4. БЭЛЧЭЭР АШИГЛАЛТ

- Малчдын хамтын оролцоонд тулгуурлан бэлчээр нутгийн тогтвортой ашиглалтыг хангаж, доройтсон бэлчээрийг сэргээх арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлнэ
- Бэлчээр хамгаалах зорилгоор мэрэгч болон байгаль орчинд сөрөг нөлөө ихтэй хортон шавьжыг устгах ажлыг жил бүр зохион байгуулна.

### 3.5. МАЛ АЖ АХҮЙ

- Малыг тооноос илүү чанарт шилжүүлж, малын төрлийг зохистой харьцаанд хүргэж, эдийн засгийн ашигтай, технологид суурилсан мал аж ахуйг бодлогоор дэмжинэ
- Махыг зах зээлд нэвтрүүлэх хяналтын горимыг сайжруулж, малыг вакцин, туулгад бүрэн хамруулан эрүүлжүүлэх ухаалаг хяналтын системийг нэвтрүүлнэ



*[Handwritten signature]*

3. Хөдөөгийн малчин өрхийг дэмжин “Малжуулах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ

### 3.6. ГАЗАР ТАРИАЛАН

1. Малын тэжээл үйлдвэрлэлийг шинээр зохион байгуулж, бодлогоор дэмжинэ
2. Орон нутгийн онцлогийг харуулсан “Халтар арвай”-н тариалалтыг нэмэгдүүлж, брэнд бий болгоно.
3. Түгээмэл тархацтай хужирын анхан шатны боловсруулалт хийж, орон нутгийн жижиг үйлдвэр бий болгоно.
4. Газар тариалан эрхлэгчдийн үйл ажиллагааг бодлогоор дэмжиж шаардлагатай техник хэрэгслээр хангана.

ДӨРӨВ. ХУУЛЬТАЙ МОНГОЛ

### 4.1. ИРГЭНДЭЭ ҮЙЛЧИЛДЭГ ЗАСАГЛАЛ

1. Нас, хүйс, хөгжлийн ялгаа, гэх мэт аливаа төрлийн ялгаварлал, дарамт, хүчирхийллийг ажлын байр, олон нийтийн бүх орчинд таслан зогсооход чиглэсэн үе шаттай арга хэмжээг тогтмол хэрэгжүүлнэ.
2. Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүл, сургуулийн орчинд хүүхдийн эрхийг хангах, ажлын байран дахь бэлгийн дарамттай тэмцэх ажлыг эрчимжүүлнэ.
3. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас өөрийн биеэр ирж уулзах боломжгүй иргэд төрийн захиргааны албан тушаалтан, албан хаагчидтай онлайнаар уулзах боломжийг бүрдүүлнэ.
4. Төрийн байгууллагаас гаргах шийдвэрт ард иргэд, төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлж, төрийн үйлчилгээний шийдвэрийг шилэн болгож ажиллана.
5. Хууль сурталчлах, таниулах ажлын чанарыг дээшлүүлж, олон нийтэд хууль зүйн мэдээллийг шуурхай, үр дүнтэй хүргэж ажиллана.
6. Төсвийн зарцуулалт, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд тавих иргэний болон хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлнэ.
7. Иргэд, аж ахуйн нэгжийн төрөөс авах үйлчилгээг бүрэн цахим хэлбэрт шилжүүлнэ.
8. Төрөөс зохион байгуулах аливаа төсөл, тендерийн сонгон шалгаруулалтыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, олон нийтэд ил тод нээлттэй болгоно.

ТАВ. АЮУЛГҮЙ, АМГАЛАН МОНГОЛ

### 5.1. ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ ЭКОСИСТЕМИЙН ТЭНЦВЭРТЭЙ БАЙДАЛ

1. Хөв цөөрөм байгуулах боломж, нөхцөлийг судлана.
2. Булаг шандны эхийг хамгаалж, ойжуулж, ногоон төгөл байгуулна.
3. Цөлжилтийг бууруулах, ойн зурvas, хориулга барьж байгуулна.



4. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагааг хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах зэргээр цогц үйл ажиллагааг шат дараалан авч хэрэгжүүлнэ.
5. Орчноо ногооруулсан иргэд, аж ахуйн нэгжийг урамшуулна.



A handwritten signature in black ink is located in the bottom right corner of the page. It appears to be a stylized signature of the name "Доржсүрэн".